



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 4/09

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус эмнэлгийн 2021 оны урсгал засвар / Барилга сантехник, Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн засвар, баталгаажуулалт, Автомашины сэлбэг хэрэгсэл/ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г. Дашжанцан /СТЭрхэлсэн дэд захирал/

Нарийн бичгийн дарга: Э. Түмэнжаргал /Эдийн засагч/

Гишүүдэд: Д. Мөнхнасан /Эмчилгээ эрхэлсэн дэд захирал

С. Нэргүйбор /Хуулийн зөвлөх/


Г. Ганчөдөр /Ерөнхий санхүүч/

Б. Буянтогтох /Инженер техникийн албаны дарга/

Г. Даваатогтох хувийн хэвшлийн төлөөлөл

2. Сонгон шалгаруулалтыг хуулийн хугацаанд явуулж, шийдвэрийг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Г. Дашжанцан/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Э. ХҮДЭРЧУЛУУН